

Сургуулийн хоолны зохион байгуулалтын тухай үндсэн мэдээлэл

Сургуулийн хоолны үйлчилгээ нь хүүхэд, сурагч ба оюутнуудад зориулсан хоолны үйлчилгээ юм.

Сургуулийн хоолны үйлчилгээ нь тэжээлийн стандартын дагуу явагддаг. Сургууль бүр заагдсан тус бүрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэглээний сагс гэж нэртэй нормыг дүүргэх ёстой. Хэрэв эмчийн зөвлөгөөний дагуу сурагчдад хоолны дэглэм баримтлах шаардлагатай байвал, сургууль нь өөрийнхөө нөхцлийн дагуу хийж болно. Хүүхдийн шашин шүтлэгийг үндэслэн түүнд хоол хийж өгөх боломжгүй.

Сургууль дараа долоо хоногийн хоолны цэсийг гаргадаг бөгөөд энэ нь чөлөөтэй үзэж болох боломжтой газарт өлгөгдсөн байдаг. Тус бүрийн хоол болгонд аллерген (харшил үүсгэгчийн) тоонууд нь заагдсан байдаг.

Сургуулийн хоолны газарт **үндсэн хоол нь** – үдийн хоол
нэмэлт хоол нь – өөглөөний цай, хөнгөн зууш, зууш

Үдийн хоол гэдэг нь: шөл эсвэл хүйтэн зууш, үндсэн хоол, ундаа, магадгүй нэмэлт (салат, амттан, жимс).

Цэцэрлэгт байгаа хүүхэд нь төлбөртэй хоол авах эрхтэй:

Бүтэн өдрийн үйлчилгээ - хөнгөн зууш, үдийн хоол, зууш
Хагас өдрийн үйлчилгээ – хөнгөн зууш, үдийн хоол эсвэл үдийн хоол, зууш
Сурагчдын байр дахь үйлчилгээ - үндсэн хоол, нэмэлт хоол ба оройн хоол

Бага сургуулийн сурагч ба дунд сургууль ба консерваторийн насанд хүрээгүй сурагч нь өдөр бүр төлбөртэй хоол авах эрхтэй: үдийн хоол

Дунд сургуулийн, консерваторийн ба мэргэжлийн дээд сургуулийн насанд хүрсэн сурагч нь сургуулийн хоолны үйлчилгээ авах боломжтой: үдийн хоол

Сургуулийн хоолны төлбөр нь санхүүгийн нормативын хэмжээгээр тогтоогддог, энэ нь тус бүрийн насны ангиллаас нь хамаарч тодорхойлогддог - хууль ёсны төлөөлөгч эсвэл насанд хүрсэн сурагч нь хоолны үнийг төлдөг, улсаас нэмэлт зардлыг ба цалингийн нормыг төлдөг.